2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЁР

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
манлайлна

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.08-Р САР



INTERNATIONAL FEDERATION
OF ASIAN AND WESTERN PACIFIC
CONTRACTORS' ASSOCIATIONS

INTERNATIONAL FEDERATION
OF CONSULTING ENGINEERS

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАТСҮХ

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ, САЛБАРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НОРМ, ДҮРЭМ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ХОТ СУУРИН ГАЗАР, ДАГУУЛ ХОТУУДЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД
- ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

ГИШҮҮНЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ГРАФИК, ҮЗҮҮЛЭЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАА САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААГААР ХАНГАЖ АЖИЛЛАЖ БАЙГАА БАЙДАЛ
- ГИШҮҮДИЙГ СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛУУЛАХ АЯЛАЛ, ВОРКШОП АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛСАН БАЙДАЛ
- ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР СУРТАЛЧИЛСАН НЬ

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна



МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**


Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

I.Нөлөөллийн үйл ажиллагааны зорилтын хүрээнд



www.mnca.mn

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД Э.БАТ-АМГАЛАН САЛБАРЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа болон газар хэлтсийн дарга нар салбарын Төрийн бус байгууллагуудын төлөөллүүдтэй 2025.08.29-ны өдөр уулзлаа.

Сайд уулзалтын эхэнд салбарын хууль эрх зүйн шинэчлэлт, хийгдэж буй ажлуудын талаар товч мэдээлэл өгөөд улмаар салбарт тулгамдаж буй асуудлууд болоод ямар зүйл дээр өөрчлөлт шинэчлэлт хийхээр байгаа, юун дээр анхаарч ажиллах тал дээр барилгын салбарын удирдлага, төлөөллүүдтэй санал солилцож цаашид хэрхэн хамтран ажиллах талаар бодлого боловсруулж ажиллахаа илэрхийллээ.

Уулзалтын үеэр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь салбарын яамтай гэрээний дагуу үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж байгаа асуудал болоод барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахимд шилжүүлэх үйл ажиллагааг улам сайжруулан Зөвшөөрлийн нэгдсэн систем /https://license.mn// нэгдсэн системд нэвтрэх ажлыг зохион байгуулж үйл ажиллагааг жигдрүүлж байгаагаа онцоллоо. Мөн хууль эрх зүйн өөрчлөлт, салбарын хүний нөөцийн судалгаа болоод Дулаан шийдэл төслийн хүрээнд нягт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа уламжилсан юм.

МОНГОЛЫН НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭНГИЙН БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛД ОРОЛЦЛОО


Монголын Ногоон Барилгын Хүрээлэн нь 2014 үүсгэн байгуулагдсан бөгөөд 2022.08-р сард Удирдах Зөвлөл, бүтэц, Ажлын алба шинэчлэгдэн, зорилго үзэл баримтлалаа Дэлхийн Ногоон Барилгын Зөвлөлтэй нийцүүлэн Монгол Улсад ногоон барилгын үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх, нэвтрүүлэх зорилгоор үйл ажиллаж байна.

Хүрээлэн нь одоогоор 70 гаруй гишүүдтэй ба барилгын салбарын чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, ногоон барилгын технологи, BestGER ногоон барилгын гэрчилгээжүүлэлт, түүний зэрэглэл, дэвшилтэт норм түүнчлэн эрчим хүчний үр ашгийн стандартыг сурталчлах, нэвтрүүлэх, талуудын хамтын ажиллагааг сайжруулан манлайлан ажиллаж байгаа бөгөөд **Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ** нь 2023 оноос эхлэн тус хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн болоод байгаа билээ.



Энэ удаагийн Бүх гишүүдийн хурлаар Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлан, зохион байгуулалт болон BestGER ногоон барилгын үнэлгээний системийг танилцууллаа. Энэхүү ногоон барилгын үнэлгээний системийг олон нийтэд танилцуулж, ногоон зээл авах, ногоон санхүүжилт авах ашиглах ба зураг төсөлд, ашиглалтад орсон барилгад ногоон барилгын гэрчилгээ олгох боломжтой юм байна.

2.НИЙГМИЙН ҮНЭ ЦЭН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



www.mnca.mn

САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД:

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС НЭЭЛТТЭЙ САНАЛ АВАХ АЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



2025.08.04-ний өдөр Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам дээр Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулагдсан бөгөөд уг хурлын үеэр барилга, дэд бүтцийн салбарын хэлэлцүүлэг явагдлаа.

Хэлэлцүүлэгт Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, салбарын төрийн бус байгууллагуудын удирдлага, төлөөллүүд оролцсон юм.

Ирэх оны улсын төсөв төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Сайдын зөвлөх И.Баттөгс, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир нар мэдээлэл хийж гарсан асуултуудад хариулт өгч, Монгол Улсын 2026 оны төсвийн хэлэлцүүлэгт зориулж ХББОСЯ-ын Орон сууцжуулалтын хэлтсийн дарга Э.Батболд танилцуулга хийсэн бөгөөд ирэх онд “Залуус” орон сууцны хорооллын бүтээн байгуулалт, Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээ, үерийн далангийн шинэчлэл, Хүннү, Хархорин хотуудын бүтээн байгуулалт, Улаанбаатар хотод хэрэгжих мега төслүүдийн хөрөнгө оруулалтын чиглэлээр танилцуулга хийлээ.

ИРГЭДИЙН ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛЫГ СУДАЛЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХАД ГИШҮҮДЭЭС САНАЛ АВАХ УУЛЗАЛТ БОЛЛОО

Зорилтын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгайлсан чиг үүрэгтэй банк байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын Захирамжаар байгуулсан. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хот байгуулалт, барилга, орон сууцжууллалтын сайд Э.Бат-Амгалан, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нар ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүргийн дагуу загварын төсөлд мэргэжлийн ТББ, компаниудаас санал авах уулзалтыг 2024.08.20-ны өдөр зохион байгуулав. Уг уулзалтыг ХББОСЯ-ны Газрын инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд удирдан чиглүүлж, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болон гишүүн компаниудын төлөөлөл, Ажлын албаны ажилтнууд оролцож санал бодлоо хуваалцлаа.



Уулзалтаар ногоон барилгын санхүүжилт, ТОСК, НОСК-ийн эрх мэдлийн хуваарилалт, дулааны тархмал эх үүсвэрийн асуудал, ажиллах хүчний зардлын асуудал, барилгын материалын ханган нийлүүлэлт, гэр хороололд

амины орон сууц барих, бага төвөгшилтэй барилга барих журмын талаарх гэх зэрэг өргөн хүрээний асуудлаар саналаа хэлэв.
МБҮА ТББ-ын гишүүн компаниудаас нэмэлтээр санал хүлээн авч нэгтгэн, яаманд хүргүүлэхээр тогтлоо.

САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

- Барилгын ерөнхий хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслүүдийн ажлын хэсэгт орж зарласан хуралд оролцож хэлэлцэж байгаа асуудлаар саналаа хүргүүлж ажиллалаа.
- Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгайлсан чиг үүрэгтэй банк байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгээс боловсруулсан орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн загварын төсөлд санал авах уулзалтад оролцов. Уулзалтад оролцогчид ногоон барилгын санхүүжилт, ТОСК, НОСК-ийн эрх мэдлийн хуваарилалт, дулааны тархмал эх үүсвэрийн асуудал, ажиллах хүчний зардлын асуудал, барилгын материалын ханган нийлүүлэлт, гэр хороололд амины орон сууц барих, бага төвөгшилтэй барилга барих журмын талаарх гэх зэрэг өргөн хүрээний асуудлаар саналаа хэлэв.

Үр дүн: МБҮА ТББ нь гишүүдийнхээ дуу хоолой болж хууль, төрийн бодлого, шийдвэрт санал бодлыг нь хүргэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулаа.

- Барилга, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэдээллийг ажиллах хүчний хомсдолын зургаан үзүүлэлтээр



баяжуулж, Дэлхийн банкны “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд тайлан 2024”, ОУХБ-ын “Хөдөлмөр эрхлэлт 2024” дэлхийн тайлангийн үзүүлэлтүүдийг оруулан “Барилга, дэд бүтцийн салбар дахь ажиллах хүчний асуудал: Ази болон Монгол Улс” сэдвээр судалгаа бэлтгэлээ.
- Барилгын салбар үүсч хөгжсөний 99 жилийн ойд зориулан “Барилга 99” сэдэвт тоон судалгаа бэлтгэж байна. Сар бүр бэлтгэдэг судалгааны цуврал контентыг бэлтгэж нийтэд танилцууллаа.
- Удирдлагын өгсөн үүргийн дагуу “Монгол Улсын барилгын зах зээлийн ерөнхий тойм” илтгэл бэлтгэсэн, хийсэн бүх судалгааг байгууллагын веб хуудсанд байршуулах, цаашид тогтмолжуулах чиглэлээр ОНХменежертэй хамтран ажиллалаа.
- Барилгын компаниудын чадавхыг үнэлэх, эрэмбэлэх судалгааны чиглэлээр SICA ХХК-тай хамтын ажиллагаа үргэлжилж 8 дугаар сарын 24-ний өдөр барилга.мн-ий хурлын өрөөнд 3 талын төлөөлөл оролцсон уулзалт зохион байгуулж ойрын үед хийх ажлаа тодорхойлж ярилцав.

Үр дүн: Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

3.ГИШҮҮНЧЛЭЛ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХУРЭЭНД

МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

www.mnca.mn

БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ХАБЭА СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил эрчимтэй өрнөж байгаатай холбогдуулан барилгын салбарт үйлдвэрлэлийн ослын тоо буурахгүй эрдэнэт хүний амь нас эндэх, хөдөлмөрийн чадвар алдах зэрэг асуудал олноор гарч байна.

Улсын хэмжээнд барилгын салбарт сүүлийн 5 жилд 180 үйлдвэрлэлийн осол бүртгэгджээ. Ослын шалтгааныг авч үзвэл, нийт ослын 39,4 хувь нь өндрөөс унах, бүдрэх, хальтрах,16,6 хувь нь эд зүйлд хавчуулагдах, 16,1 хувь нь унаж байгаа эд зүйлд цохиулах гэсэн хүчин зүйлээс хамаарч байна.

Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ихэнхи аж ахуйн нэгж, байгууллага нь ХАБЭА-н хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлдэггүй, ХАБЭА-н ажилтан, алба, хэлтсийг зохих орон тоогоор ажиллуулдаггүй,

орон тооны тогтвортой ажилчид байхгүй, олон чиглэлээр түр зуурын туслан гүйцэтгэгч авч ажиллуулдаг, ХАБЭА-н урьдчилан арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө зардал гаргадаггүй, ХАБЭА-н менежментийн тогтолцоо нэвтрүүлдэггүй зэрэг нь энэ салбарт үйлдвэрлэлийн осол гарах, улмаар ажилтны амь нас, эрүүл мэнд хохирох үндсэн шалтгаан болж байгаа ба үүнээс үүдэлтэй Барилга, уул уурхай, зам тээвэр гэвэл салбар салбаруудын онцлогт тохируулсан ХАБАЭ-ын сургалт явуулдаг байх нь чухал болоод байна.

Монгол улсад барилгын салбар үүсч хөгжсөний 99 жилийн ойг угтан Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь ХББОСЯ, БХТ ТӨҮГ, МБИХолбоо-той хамтран удирдах ажилтнуудад ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт болон байгууллагын ХАБЭА -н чадварын мэдлэг олгож чадавхжуулах, болзошгүй осол эрсдэлээс хамгаалах зорилгоор 2025.08.14-ний өдөр “БАРИЛГЫН ХАБЭА УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ”-ыг зохион байгууллаа. Энэхүү сургалт нь барилгын салбарынхаа ажлын онцлог, эрсдэлийн үнэлгээ, техник технологи, аюулгүй байдал нь ямар хууль, эрхзүйд нийцүүлсэн байх ёстой юм, салбарын онцлогийг тусган барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн мөрдөж ажиллах вэ, ямар аюул эрсдэл учрах вэ, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ, ямар хууль эрхзүйг баримтлан ажиллах вэ гэдгийг сургалтаараа хүргэх онцлогтой байсан юм.



Тус сургалтын үеэр, сургалтад хамрагсдад дунд олон улсын жишиг, стратеги төлөвлөлт, анхаарах асуудал зэрэг сонирхолтой сэдвээр мэдээлэл, нээлттэй сэтгэгдлийг сонсон, хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлсэн бөгөөд гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагуудад зохион байгуулагчийн зүгээс нэгтгэн хүргэхээр болсон юм.

Сургалтаар оролцсон инженер, удирдах ажилтнуудад Мэргэжил дээшлүүлэх СОНГОН суралцах 0.5 цаг цагийн гэрчилгээ гардууллаа.

МОНГОЛ-ХЯТАДЫН БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМЫН ТАЛААР ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Монгол Улсын Засгийн газрын зүгээс барилга, зам гүүр, дэд бүтцийн томоохон мега төслүүдийг хэрэгжүүлж, төлөвлөж буй энэ цаг үед хоёр орны барилга дэд бүтцийн салбарын хувийн хэвшлийн харилцааг өргөжүүлэх, Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай төслүүдэд хоёр улсын салбарын компаниудыг хамтран ажиллах, түншлэх боломжийг олгох, холбох Монгол-Хятадын “Барилга, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын форум”-ын талаар гишүүн байгууллагуудтай санал солилцох цуврал уулзалтыг 2025.08.26-ны өдөр зохион байгууллаа.

Уулзалтыг цувралаар хийх бөгөөд форумын зохион байгуулалт, ач холбогдол, үр өгөөжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх гишүүдэд дэлгэрэнгүй мэдээллийг өглөө.

Дашрамд дурдахад МБҮА ТББ нь 2010 оноос хойш БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-тай харилцаа тогтоож өнөөдрийг хүртэл хоёр улсын хувийн хэвшлийн барилгын аж ахуйн нэгжүүдийг холбох, хамтын ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд жил бүр тус байгууллагаас зохион байгуулалдаг “ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЭЦ, БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ” форумд гишүүн байгууллагуудаа хамруулах, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХОМСДОЛТОЙ ХҮНД ЦАГ ҮЕД МОНГОЛ УЛСАД СЭХ-ИЙН ШИНЭ ҮЕИЙН ТЕХНОЛОГИ НЭВТЭРЧ БАЙНА

Монгол Улсын ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих, СЭХ-ийг барилгын салбарт бүрэн уялдуулах шинэ үеийн технологи болох BIPV (Building-Integrated Photovoltaics) нь манай улсад албан ёсоор нэвтэрлээ.

Монгол Улс эрчим хүчний хомсдолд орсон хүнд цаг үед Монгол Улсын Ногоон таксономийн шаардлага хангасан ногоон барилга, ногоон дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхэд нь шаардлагатай технологийн шийдлээр хангах, ногоон бүтээгдэхүүн хөгжүүлэхээр хамтран ажиллахаар Монгол банк, Санхүү, банкны эмэгтэйчүүдийн холбоотой хамтран, төр, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд арга хэмжээний нээлтийг 2025.08.22-ны өдөр хийлээ.



BIPV гэдэг нь: Энгийнээр тайлбарлахад нарны энерги, гэрэл гэгээгээр эрчим хүч үйлдвэрлэдэг барилгын материал юм. Цонх, дээвэр, фасад гэх мэт барилгын үндсэн материал нь өөрөө цахилгаан үүсгэх чадвартай болж, шууд утгаараа эрчим хүчний хэрэглээг хангах боломж бүрдүүлдэг шинэ үеийн технологи юм.

Монгол Улсын Засгийн газар, Green Climate Fund зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зорилтот байгууллагуудаас санхүүжилт татан төвлөрүүлж арилжааны банкуудаар дамжуулан BIPV суурилуулсан ногоон барилгын төслүүдэд зээл олгож, цаашлаад иргэдэд зориулсан бага хүүтэй ногоон ипотекийн зээлийг гаргах, барилгын компаниудад зориулсан цогц

дэмжлэг үзүүлэхээр боллоо. Ингэснээр иргэдэд өөрийн байр, орон сууцдаа цахилгаан үйлдвэрлэх, эрчим хүчний төлбөрийг тэг болгох, ногоон зээл, ипотекийн тусгай нөхцөлтэй хөнгөлөлт эдлэх, “Тогтвортой хэрэглэгч” статустай болох ба карбон кредит хүртэх боломж нээгдэнэ. Харин барилгын компаниудад:

- BIPV технологи нэвтрүүлснээр барилгын төслийн уур амьсгалын шалгуурт нийцнэ.
- Гадаад, дотоодын санхүүжилт татах боломж нэмэгдэнэ.
- “Ногоон барилга” гэрчилгээ авахад илүү хялбар болно.
- Эрчим хүчний аюулгүй байдал, бие даасан байдлыг бүрдүүлсэн ухаалаг орон сууц хөгжүүлэх боломж бүрдэнэ.
- Карбон кредитийг бий болгож дэлхийн зах зээлээс хувь хүртэх боломж бүрдэнэ.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын Гишүүн BIB Discovery LLC нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн BIPV технологийг Монгол Улсад онцгой эрхтэйгээр нэвтрүүлж, Монгол банк, МУ-ын Хөгжлийн банк, Санхүүгийн зохицуулах хороо, банкны салбарынхантай хамтран, ногоон зээлийн хүүг нэг оронтой тоо руу оруулах, айл өрх бүрд бие даасан эрчим хүчний шийдлийг хүргэж үйлчлэх зорилго тавин ажиллаж байна.

БАРИЛГЫН САЛБАРЫН 99 ЖИЛИЙН ОЙ, БАРИЛГАЧДЫН БАЯРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Монгол улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ой, Барилгачдын баярын хөтөлбөр, зохион байгуулах ажилын мэдээллийг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчид, Дэд ерөнхийлөгчид, Удирдах зөвлөлийн гишүүдэд мэдээлэл хүргэн, бүртгэл үүсгэн ХББОС яаманд нийт 13 хүний нэрийг хүргүүлсэн.

ГИШҮҮДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Гишүүн байгууллага болох хүсэлтэй байгууллагуудад мэдээллийг хүргэн ажилласан ба гишүүдээс ирсэн саналуудыг авч боломжтой мэдээлэл болон туслалцаа үзүүлэн ажилласан.

ТАТВАР, АВЛАГЫН АСУУДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

- Гишүүнчлэлийн татвар, авлагын асуудалтай холбоотой ажлыг үргэлжлүүлсэн
- Татварын өр авлагатай гишүүдэд хувь хувьд мэдээлэл хүргэсэн

ДАТА БААЗ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ШИНЭЧЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Гишүүнчлэлийн дата баазын мэдээллийг иж шинэчлэсэн
- Шинээр элссэн байгууллагуудын мэдээллийг нөхөн оруулсан
- Дутуу мэдээлэл бүхий байгууллагуудын цахим хаяг зэргийг бүрэн болгосон
- Мэдээллийн баазыг өргөжүүлэн хөгжүүлсэн
- Нийт гишүүдийн хуучин Viber группээс шинэ Viber группруу шилжүүлэх ажил зохион байгуулсан
- Шинэ группт орж амжаагүй гишүүдийг дахин шалгаж, идэвхжүүлсэн
- Харилцааны шинэ сүлжээг бий болгон ажиллуулсан
- Зураг төслийн компаниудын мэдээллийг холбогдох гишүүдэд хүргэсэн

ГАДААД ХАРИЛЦАА:

“НЭГ БҮС НЭГ ЗАМ“ УУЛЗАЛТАД МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР ИЛТГЭЛ ТАВИЛАА

БНХАУ-ын Шандон мужийн Линьи хотын даргын урилгаар Хүннү хотын захирагч М.Батбаяр, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Хүннү хотын Хөгжлийн корпорацийн захирал Г.Гүнболд нар зочилж албан ёсны айлчлал хийлээ.






Линьи хот нь 12 сая хүн амтай, сүүлийн 20 жилд төлөвлөлтөө шинэчлэн орчин үеийн шинэ хотыг байгуулж, байршлын давуу талаа ашиглан цахим худалдаа, ложистикийн төвүүдийг байгуулан, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын 1200 гаруй компани Линьи хотоос төрөл бүрийн бараа материал худалдан авч импортолж байна. Линьи хотын дарга Монгол Улсын зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж хамтран ажиллах шинэ эхлэл тавигдаж байгааг онцлон тус хотын Хот төлөвлөлтийн үзэсгэлэн, Радио телевизийн цамхаг, барилга бүтээн байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд, Линьи хотын худалдааны хөндий, тээвэр ложистикийн төвтэй танилцууллаа. Хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх “Нэг бүс нэг зам“ уулзалт арга хэмжээнд 200 гаруй төлөөлөгчид оролцож, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх Монгол улсын барилга бүтээн байгуулалтын салбарын талаар илтгэл танилцуулж, оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа. Цаашид Монгол Улсад барилгын материал нийлүүлэх, хот төлөвлөлт, барилгын төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

БУСАД БЭЛТГЭЛ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- СМЕС байгууллагын (2025.08.11–14) төлөөлөгчдийг 3-4 хоногийн турш Монголд хүлээн авч ажиллан хөтөлбөр, зохион байгуулалтын процессын талаар хэлэлцэн шийдвэрлэв.
- БНСУ-ын “Korea Build 2025” үзэсгэлэнд оролцсон Оршил Констракшн ХХК, Бетон Арматур ХХК, Эфэс констракшн ХХК зэрэг байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авахад зохион байгуулалт, хөтөлбөр, орчуулагч сайн ажиллаж үр дүнтэй байсан талаарх үнэлгээг өглөө.
- 2025.10.29–30-нд Малайзын Куала Лумпур хотод болох ХОЁР ДАХЬ УДААГИЙН ДИЖИТАЛ БАРИЛГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ”-ын мэдээллийг судлан орчуулж, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захиралд танилцууллаа.
- БНХАУ-ын Олон улсын гэрээлэгчдийн холбоо болон СМЕС-тэй 2025.09.18–20-нд болох үйл ажиллагааны зохион байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэж байна.
- Хамтран зохион байгуулагч талуудтай тогтмол харилцаа холбоо тогтоон ажиллаж байгаа.
- Зочид төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл ажлууд
- Холбогдох төсөв, төлөвлөгөө, мэдээлэл түгээх, бүртгэл зохион байгуулах ажлуудыг хийсэн.
- Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын тушаал батлуулж ажлын хэсэг байгуулсан.
- Гишүүн байгууллагуудад зориулсан уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1150 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.



БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн **278**-н хуулийн этгээдийн хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.07.31, 2025.08.07, 2025.08.14, 2025.08.21, 2025.08.28-ны өдрүүдэд 5 удаа цахимаар илгээв.





Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор **556** хуулийн этгээдийн хүсэлт хянагдаж, **5** удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар **278** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Үүнээс: Сунгалтаар **7**, Нэмэлтээр **74**, Шинээр **194**, Дахин олгохоор **3** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 7 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 5, Зураг төслөөр 2. Нэмэлтээр 74 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 53, Зураг төсөл боловсруулалтаар 20, өргөх байгууламжаар 1. Шинээр 194 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 170, Зураг төсөл боловсруулалтаар 18, Өргөх байгууламжаар 6. Дахин олгохоор барилга угсралтын 3 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 5 удаагийн баталгаажуулалтаар давхардсан тоогоор 271 хуулийн этгээдийн материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, өнөөдрийн байдлаар 7-н хуулийн этгээдийн хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.


– Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 549 хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж, **1177** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тавив.

- БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон ХББОССайдын 8-н удаагийн тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 5116, ЗТ: 1016, ӨБ: 184 хуулийн этгээдийн нийт **6316** мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.
- БҮАТЗ-тэй хуулийн этгээдийн мэдээллийн санд “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4399, ЗТ: 897, ӨБ: 162 нийт **5458** хуулийн этгээдийн мэдээллийг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд тайлант хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар гарсан БУ: 432, ЗТ: 70, ӨБ: 14 нийт **516**-н хуулийн этгээдийн мэдээллийг хүргүүлсэн.
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын тушаалыг үндэслэн **301**-н хуулийн этгээдтэй гэрээг байгуулж, “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тухай хуулийн дагуу **292.550.000** төгрөгийн хураамжийг төвлөрүүлэв.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа талаарх зарлан мэдээллийг нийгмийн сүлжээгээр дамжуулан **158**-н хуулийн этгээдийн мэдээллийг байршуулав.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд зөвшөөрлийн тухай хуулинд заасны дагуу тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа талаарх БУ:143, ЗТ:11, ӨБ:4 нийт 158 хуулийн этгээдэд масс мессеж хүргүүлсэн.
- ХББОССайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авч, гэрээ байгуулах тухай БУ:323, ЗТ:46, ӨБ:13 нийт **382** хуулийн этгээдэд масс мессеж хүргүүлсэн.
- **278** хуулийн этгээдээс үйлчилгээний хураамж болгон **162.500.000** төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 240004000431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг шинээр болон нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай 2025 оны 167, 168, 169, 170, 171, 172, 187, 188 дугаар нийт 8-н тушаалыг үндэслэн тайлант хугацаанд БУ:432, ЗТ:70, ӨБ:14 нийт **516**-н ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

“БАРИЛГЫН САЛБАРЫН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИД (БЖДБЭ)-ИЙГ ЧАДАВХЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ” дэд төслийн санал боловсруулаа





МБҮА ТББ нь 2018 оноос хойш Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл I, II” төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв, Пипл Ин Нийд ОУТББ, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци, Монголын Эмэгтэйчүүдийн Сан-тай хамтран хэрэгжүүлж ирлээ.

Төслийн үр дүнд 2025.08-р сарын байдлаар 241 барилгын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч (БЖДБЭ)-дийг барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалга болон бусад чиглэлээр чадавхжуулан, 3308 айл өрхийг дулаалсны үндсэн дээр хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж байна.

Төслийн I үе шатыг 2018-2022 онд хэрэгжүүлсэн бол II үе шатанд үйл ажиллагаагаа улам өргөжүүлж Монголын уур амьсгал, нөхцөлд нийцсэн, үр ашигтай эрчим хүчний шийдлүүдийг боловсруулан нэвтрүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулан, эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хувьд үр ашигтай байх зах зээлийг бий болгох зорилготойгоор 2022-2026 онд хэрэгжүүлж байгаа болно.

“Дулаан шийдэл II” төслийг хамтран хэрэгжүүлэгчид нь Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөр тэргүүтэй гадны санхүүжүүлэгчдээс 90 хувийн санхүүжилт татсан. Үлдсэн 10 хувийн санхүүжилтээ хамтын санхүүжилт хэлбэрээр өөрсдөө олох үүрэг хүлээж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд манай байгууллага “Дулаан шийдэл II” төслийг хамтран хэрэгжүүлэгчийн хувиар Бодь групп/Бодь пропертийз ХХК болон Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас зарласан төсөл сонгон шалгаруулалтад зориулан дэд төслүүд боловсруулан шалгарч, тодорхой хэмжээний хамтын санхүүжилт татан, эдгээр дэд төслийг амжилттай хэрэгжүүлж, санхүүжүүлэгчдэд үр дүнгээ хүлээлгэн өгөөд байна.

Энэ удаад бид **“Барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид (БЖДБЭ)-ийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах нь”** дэд төслийн санал боловсруулаа.

ДЭД ТӨСЛИЙН САНАЛЫН ХУРААНГУЙ

Төслийн нэр	Барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид (БЖДБЭ)-ийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах нь
Төслийн зорилго	- Хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж, байгаль орчноо хамгаалах - Гэр хорооллын иргэдийн эрүүл мэнд, өрхийн эдийн засагт эерэгээр нөлөөлөх, тадний амьдралын чанарыг дээшлүүлэх - Барилгын салбарын БЖДБЭ-чдийг чадавхжуулан хөгжүүлж, барилгын эрчим хүч хэмнэлтийн чиглэлийн ажлуудад зуучлан, нэмэлт орлого олох боломжоор хангах, үйл ажиллагаг нь сурталчлан таниулж, тогтвортой байдлыг нь бэхжүүлэх
Төслийн хүрэх үр дүн	Дулаан шийдэл II төслийн доорх тоон зорилтуудад хувь нэмрээ оруулна. Үүнд: - 5900 өрхөд шууд хүрч ажиллах - 1000 өрхийг ногоон зээлд зуучлах - 160 барилгын салбарын БЖДБЭ-чдийг чадавхжуулах - 11 банк, ББСБ, хадгаламжийн бүлэгтэй хамтарч ажиллах - 5 эрчим хүчний хэмнэлттэй шийдэл хөгжүүлэх - 1 аймагт үйл ажиллагаагаа өргөжүүлэх - 2,2 сая хүнд барилгын эрчим хүч хэмнэлтийн ач холбогдлын талаар мэдээлэл хүргэх, нөлөөлөх
НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтот дэд төслийн нийцэж буй байдал	- Ядуурлыг устгах - Эрүүл мэндийг дэмжих - Жендэрийн тэгш байдлыг хангах - Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх - Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих - Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
Хэрэгжүүлэх арга хэмжээ	- Барилгын салбарын БЖДБЭ-ийг гүнзгийрүүлэн чадавхжуулах - Гүнзгийрүүлж чадавхжуулсан БЖДБЭ-чдийг барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ач холбогдлын талаар айл өрхүүдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, дулаалгын ажилд зуучлах - Ажилд зуучилж буй БЖДБЭ-чдийн гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор барилгын багаж, хэмжээлах хэрэгслээр хангах, урамшуулах - Хамтран ажиллаж буй БЖДБЭ-чдийн цаашдын тогтвортой байдал хангах, хамтын ажиллагаог өргөжүүлэх, сурталчлан таниулах, борлуулалтыг нь нэмэгдүүлэх зорилгоор арга хэмжээнүүд зохион байгуулах
Санхүүжүүлэгчдэд үүсэх давуу талууд	- Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй Дулаан шийдэл II төсөлтэй хамтын ажиллагаанд өргөжүүлэх - Дотоодын болон олон улсын төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаанд өргөжүүлэх - НҮБ-ын Тогтвортой хөгжлийн тодорхой зорилтуудыг хангахад хувь нэмрээ оруулах зорилготой төслийн үр дүнд нэгдэх - Тодорхой, бодитой, туршлагатай, үр дүн нь хэмжигдэхүйц төсөлд хөрөнгө оруулсан үр шимээ богино хугацаанд хүртэх - Гэр хорооллын иргэд, барилгын салбарын БЖДБЭ-чдээс гадна орон нутгийн захиргаа, барилгын материал нийлүүлэгчид, санхүүгийн бусад байгууллага, олон улсын хөгжлийн агентлагууд гэх мэт бүлэгт хүрч ажиллах - Дулаалгын ажлыг гардан гүйцэтгэж буй барилгын салбарын БЖДБЭ-чдийг чадавхжуулан хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулснаар нэгоон зээлийн тоо, хэмжээнд эерэгээр нөлөөлөх, зээл авсан айл өрхүүд сэтгэл ханамжтай байх - Төслийн санхүүжүүлэгчидийн нэг болсноор, санхүүжилт олгосноос хойш зохион байгуулах барилгын салбарын БЖДБЭ-чдээ чиглэсэн сургалт, арга хэмжээнүүдэд нэрийг нь дурдах, логог нь байршуулах - Дэд төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүй санхүүжилтээс өөр нэмэлт санхүүжилт, зардал гаргах шаардлагагүй.
Үргэлжлэх хугацаа, тайлагнах хэлбэр	2025.09-2026.05-р сар, гурван сар тутамд, бичгээр
Хэрэгжүүлэх байршил	Улаанбаатар хот болон Дархан-Уул аймаг

Хэрэв Та бүхэн энэхүү дэд төслийн саналын хураангуйтай танилцаад, дэлгэрэнгүй мэдээлэл авах, хамтран ажиллах хүсэлтэй бол МБҮА ТББ-ын Төслийн нэгж / + (976) 7011 1515-3 /-тэй холбогдох боломжтой.

Барилгын салбарын БЖДБЭ-чдэд зориулан зохион байгуулах сургалт, арга хэмжээнүүдийн урьдчилсан хуваарь гаргалаа

“Дулаан шийдэл II” төслийн нэгж нь дараах сургалт, арга хэмжээг барилгын салбарын БЖДБЭ-чдэд зориулан, төслийн бусад байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна. **Үүнд:**

Д/д	Сургалт, арга хэмжээний нэр	Урьдчилсан хуваарь
1	"Барилга экспо 38" олон улсын үзэсгэлэнд оролцож, төслийн болон дулаалгын бригадын үйл ажиллагааг танилцуулах	2025.09.12-09.14
2	Барилгын дулаалгын материалуудын шинж чанар, давуу болон сул талын тухай сургалт	2025.09-р сардаа багтаан
3	Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд сургалт	2025.09.23/09.25
	Спортын нөхөрсөг өдөрлөг	2025.10-р сарын эхний 7 хоногт
	Төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын БЖДБЭ-чдийг борлуулалтыг дэмжих маркетингийн кампанит ажил	2025.09-р сараас он дуустал
	Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ-камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт	2025.11.13
	Төсөлтэй хамтран ажилладаг БЖДБЭ-чдийн чадавхийг үнэлэх, дулаалгын технологи, барилгын дулаан хамгаалалтын чиглэлээр давтан сургах арга хэмжээ	2025.11.21
	Бизнесийн холбоо тогтоох чөлөөт арга хэмжээ-2025 оны ололт, амжилтаа дүгнэх нэгдсэн арга хэмжээ	2025.12.12

ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН БАЙДЛААР 463 ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫГ ИЛРҮҮЛЭХ АЖИЛД ЗУУЧИЛСАН БАЙНА



“Дулаан шийдэл II” төслийн Дуудлагын төвөөр оны эхний 8 сарын байдлаар хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээний 463 захиалга ирснийг 33 Дулаалгын зөвлөх-д зуучлав. Үүнээс одоогийн байдлаар 277 айл өрхөд хэмжилт, үнэлгээ хийснээс 16 айлд дулаалгын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Дулаалгын ажлыг төрлөөр нь авч үзвэл, бүтэн дулаалга-4, дээвэр-4, хана 1, хана+дээвэр/хана+суурь гэх мэт хосолмол дулаалга байна. Иймхүү төслийн шугамаар ажилд зуучлуулсан барилгын салбарын БЖДБЭ (дулаалгын зөвлөх)-үүдийн ажлын гүйцэтгэлийг Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, хагас жилийн шилдэг гүйцэтгэгчдийг тодруулж, урамшуулах болно. Энэ хугацаанд хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээ, дулаалгын ажилтай холбоотой нийтдээ 104 хэрэглэгчээс санал, хүсэлт ирүүлснийг шийдвэрлэв.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.08-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	41
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	16
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	17
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	1
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	42
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	15
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	27



МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН УНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn